

## ШИНЭТГЭЛИЙН ҮЕИЙН ХЯТАД МОНГОЛЫН ХАРИЛЦАА (1980-1995)

Ду Шивэй (БНХАУ-ын аспирант)\*

Хятад улсын өөрчлөлт шинэчлэлтийг 1978 онд хуралдсан ХКН-ын 11 дэх удаагийн III бүгд хурал дээр Дэн Сяопин тэргүүтэй Хятадын улс төрийн шинэчлэлийн талыг баримтлагч удирдлагаас шинэтгэл хийх, нээлттэй байх бодлого дэвшүүлж, 1982 онд хуралдсан ХКН-ын XII их хурлаар уг бодлогыг улам тодорхой болгосон юм. Өөрчлөлт шинэчлэлтийг хөдөө тосгоноос эхэлж, дараа нь том жижиг хотуудад хийх эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийсний дараа бүх салбарыг хамруулах, гадаад харилцаанд нээлттэй байхад чиглэсэн бүхэл бүтэн түүхэн зорилтыг дэвшүүлсэн болно.

Дэн Сяопин тэргүүтэй шинэчлэлийн талыг баримтлагч удирдлагаас Хятадын өвөрмөц маягийн социализм байгуулах тухай улс төрийн бодлого, үзэл санааны тогтолцоог бий болгож өгсөн юм. Дэн Сяопин Хятад улсыг 1981 оноос 2000 он хүртэл хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэхдээ хүн тутамд ноогдох үндэсний орлогын хэмжээг дунджаар 300 доллараас 800 долларт хүргэх, улс ардын аж ахуйн нийт бүтээгдэхүүний түвшинг чинээлэг болгож, дараа нь 30-50 жилийн дотор БНХАУ-ыг эдийн засгийн хөгжлөөр хөгжингүй орнуудын түвшинд хүргэх юм. Өөрчлөлт, шинэчлэлт нээлттэй бодлогын арга хэрэгслэл зорилтыг 3 үе шаттайгаар явуулна. Юуны өмнө зам тээвэр, харилцаа холбоог сайжруулах явдал бол эдийн засгийг хөгжүүлэх анхдагч алхам юм. Өөрчлөлтийн гол стратеги бодлого нь **нэгд** хөдөө аж ахуй, **хоёрт** эрчим хүч, зам харилцаа, **гуравт** боловсрол шинжлэх ухааны ололтод зайлшгүй түшиглэх шаардлагатай. Ингэснээр Хятад улсын эдийн засгийн хөгжил хөгжингүй орнуудын түвшинд дөхөж очих магадлалтай юм. Үүний дотор чухлаас чухал асуудлын нэг бол энэ хугацаанд зуун саяар тоологдох төрөл бүрийн мэргэжлийн боловсон хүчний эгнээг бий болгосноороо тэдний авъяас билгийг дэлгэрүүлэх явдал бөгөөд энэ үед удирдах хүмүүс, ухаантныг тодруулж, ухаантныг нэгтгэж, ухаантныг ажиллуулж сурсан байх явдлыг гол зорилтоо болгосон байх болно.

Хятадын хүн амын 82 хувь нь хөдөө тосгонд аж төрдөг учраас өөрчлөлт шинэчлэлтийг хөдөө аж ахуйгаас эхлэх болсон байна.

Хөдөө аж ахуйн асуудлыг шийдвэрлэсний дараа үйлдвэр аж ахуйн шинэтгэлийн гол асуудал нь улсын том, дунд үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, өмчлөх эрх, аж ахуйг эрхлэх эрхийг салгах зэрэг нь өөрчлөлт шинэчлэлтийн нэг чухал гол үзүүлэлт болно. Үүнд үйлдвэр аж ахуйн газруудын хамтлаг бий болгох, хүчин чадлыг зузаатгаж, мэдээллийг олж авах чанарыг дээшлүүлэх явдал юм. Санхүүгийн өөрчлөлт нь банкыг жинхэнэ банкны ёсоор ажилладаг болгох

---

\*ЗХАСТ-д аспирантурт суралцах хугацаандаа бичсэн дэд докторын зэрэг горилох зохиолын хэсгээс товчлон авав

хэрэгтэй юм. Санхүүгийн үйл ажиллагаа бол орчин үеийн эдийн засгийн гол цөм бөгөөд мөнгө, санхүүгийн ажлыг сайжруулчих юм бол бүхэлдээ эдийн засаг сайжрах үндэс болно.

Өөрчлөлт шинэчлэлтийн түүхэн явцад Дэн Сяопины дэвшүүлсэн Хятадын өвөрмөц маягийн социализм байгуулах бодлого ба үзэл санааны хүрээнд социалист эдийн засгийн зах зээлийн онолыг бий болгож, энэ хугацаанд Хятад улс өөрчлөлт шинэчлэлт хийх үндсэн зургаан чиглэлийг тодорхойлов.

1. Хөдөө тосгон дахь ардын коммуныг татан буулгаж, тариачдын худалдан авах борлуулах чадварыг дээшлүүлж, өрхийн гэрээт хариуцлагын системийг бий болгож, аж ахуйгаа эрхлэн явуулахад хосслсон тогтолцоог сайжруулж, гацаа тосгоны аж ахуйн нэгжийг түлхүү хөгжүүлэх

2. Улсын мэдлийн аж ахуйн нэгжүүдийг зах зээлд хамруулах

3. Үнийг чөлөөлж зохицуулах

4. Худалдан авах, борлуулалтыг чөлөөт гүйлгээнд оруулах, олон талт гүйлгээний сүлжээг буй болгох

5. Эхний алхамд шууд ба шууд бус хязгаарлалтай тогтолцоог буй болгох

6. Гадаад харилцааг хөгжүүлж, чөлөөт бүсүүдийг байгуулж, дэлхий нийтийн зах зээлийн горимд тохирохуйц эдийн засгийн гадаад харилцааг буй болгох

Эдгээр чиглэл нь Хятадын социализмын нөхцөлд зах зээлийн эдийн засгийг хөгжүүлнэ гэсэн үг бөгөөд зах зээлийн эдийн засаг нь ерөнхийдөө улс орнуудын түүхэн онцлог нөхцөл, байдал нийгмийн үндсэн байгуулалтай нягт холбоотой учраас өөр өөрийн онцлог нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх үйл явц мөн

Хятад дахь зах зээлийн эдийн засгийн онолын ойлголт нь гол хэдэн үе шаттай юм.

1. Төлөвлөгөөт эдийн засгийг гол болгон хөгжүүлж, зах зээлд зохицуулах дагавар үе шат болгон хэрэгжүүлэх (1979 оноос)

2. Татварын эдийн засгийн төлөвлөгөөт үе шатны хэрэгжилт (1984 оноос)

3. Төрийн зохицуулалттай зах зээл ба зах зээлийн аж ахуйн нэгжид шилжүүлэх үе шат (1987 оноос)

4. Төлөвлөгөөт эдийн засгийг төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засагтай нэгтгэх үе шат (1989 оноос)

5. Социалист зах зээлийн эдийн засгийн онолыг дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх үе шат (1992 оноос)

Өөрчлөлт шинэчлэлтийн эдгээр үйл явцад доорхи хэдэн зүйлийг чухалчлан үзэх нь зүйтэй.

1. Улсын өмчинд байгаа эдийн засгийн салбаруудад шинэчлэлт хийх ажлыг хурдавчилж, эдийн засгийн салбаруудыг өмчлөх эрхийн харилцааг тодорхойлон аж ахуйн нэгжийн өмчлөх эрхийг зааглаж улсын мэдлийн өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, улсын өмчинд байгаа эд баялагтай хэрхэн харьцахыг зохицуулах, улсын өмчийн аж ахуйн нэгжүүдийг жинхэнэ зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх

2. Зах зээлийн тогтолцоог төгөлдөржүүлэхдээ таваарын зах зээл, мөнгөн гүйлгээний зах зээл, хөдөлмөрийн зах зээл, газрын зах зээл зэрэг зах зээлийн боловсронгуй тогтолцоог бий болгож, таваарын үнэ ба үнэ ханшинд үйлчлэх хүчин зүйлтэй холбогдон гарч ирэх зах зээлийн эрэлт хэрэгцээг соргогоор тусгасны үндсэн дээр нөөц баялагийг зүй зохистойгоор хуваарилах, ингэснээрээ зах зээлийн хүчин чадлыг бүрэн гүйцэд ашиглах нь нөөц баялагийг хуваарилахад ч зохицуулах үүрэг

бүхий юм.

3. Зах зээлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох өрсөлдөөнийг бий болгож, зах зээлийн эдийн засгийн дотоод эрэлт хэрэгцээний дагуу зах зээлийн эдийн засагт холбогдох бүх төрлийн хууль эрхийн актуудыг бий болгосон байх. Жишээлбэл: экспорт, импортын дүрэм журам, арилжаа хийх болон зах зээлд өрсөлдөх дүрэм горим зэрэг болно.

4. Зах зээлийн эрэлт хэрэгцээний дагуу Засгийн газрын удирдлагын тогтолцоог сайжруулах засаг төрийн албан тушаалтны ажиллах чадварыг харгалзан сэлгээ хийж, төрийн бүтцэд цомхотгол явуулж, төр захиргааны албан хаагчдын тоог цөөлж, удирдлагын үр ашгийг нэмэгдүүлэх нь чухал.

Хятадын шинэтгэл нь 3 үе шаттай явагдсан юм.

**Нэгдүгээр үе** (1978 оны 12 сараас 1984 оны 9-р сар) Энэ хугацаанд хөдөө аж ахуйд хийх өөрчлөлт шинэчлэлтийг гол болгож эдийн засгийн онцгой районыг үүсгэн хөгжүүлж эхэлсэн.

**Хоёрдугаар үе** (1984 оны 10 сараас 1991 оны 12-р сар) Энэ хугацаанд өөрчлөлт шинэчлэлт хийх ажлыг хот руу шилжүүлсэн.

**Гуравдугаар үе** (1992 оны 1-р сараас одоо хүртэл) Энэ үеийн онцлог нь хуучин тогтолцоог шинэ тогтолцоонд шилжүүлэхийн зэрэгцээгээр гол мөрөн, далай тэнгис, хил хязгаарын дагуух бүх байршлыг хамарсан бүх салбарын хэмжээгээр гадаадтай чөлөөтэй харилцаж нээлттэй байх юм.

Хятадад далайн эргээс эхлээд дотоод бүс нутгийг хамарсан бүх талын олон шатны олон хэлбэрийн нээлттэй байдал бий болоод байна. Одоогийн байдлаар эдийн засгийн тусгай бүс 5, эдийн засаг техникийн нээлттэй бүс 32, улсын дээд зэрэглэлийн шинэ технологийн чөлөөт бүс 52, хятадын гадаадад нээлттэй хот, сянь 900 гаруй байна. Одоогийн байдлаар Хятад улс дэлхийн 221 улс бүс нутагтай худалдааны харилцаатай байгаагийн дотроос Азийн 42, Африкийн 57, Европын 47, Латин Америкийн 47, Далайн орнуудын 43, Умард Америкийн 5 улс байна. Тус улсын худалдааны гол түнш нь Япон, Гонконгийн бүс нутаг, Европ ба АНУ болж, экспорт, импортын нийт хэмжээ нь дэлхийн худалдаанд эзлэх хувийн жингээр 1978 онд 0.9 хувь байснаа 1993 онд 3.2 хувь болон өсч экспортын нийт хэмжээгээрээ дэлхийн бүх улсуудын дунд 1978 онд 32-р байранд байсан бол 1992 онд 11-р байранд орох боллоо.

Монгол Улсын өөрчлөлт шинэчлэлтийн тухайд гэвэл тус улсад өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийн үзэл баримтлал нь гадаад, дотоод нөхцөл байдлын нөлөөгөөр маш ярвигтай, олон талт, зам туулжээ. 1990 оноос өмнөх монгол улсын улс төр, нийгэм эдийн засгийн байгуулал, Зөвлөлт маягийн загвартай байсан бөгөөд эдийн засгийн хөгжлийн энэ загварын учир дутагдлыг нийт ард түмэн аажмаар мэдсэн байлаа.

1981 оны 5-р сард хуралдсан МАХН-ын XVIII хурлаас "аж ахуйн механизмыг боловсронгуй болгон, тулгамдсан асуудлыг дотоод ажлын төлөвлөгөөнд тусгаж, эцэст нь нийгмийн аливаа шаардлагад нийцэх аж ахуйн механизм бий болгох нь бидний зорилт юм гэж заажээ. 1981 оноос хэд хэдэн салбарын аж ахуйн механизмыг боловсронгуй болгох туршилт хийж эхэлсэн ба 1985 оноос энэхүү туршилтын хүрээ өргөжиж, хөнгөн Хүнсний Үйлдвэрийн яам, Тээвэр Холбооны Яамны системийн газруудыг хамарчээ. Монгол улс социализмын улс төр, эдийн засгийн байгууллыг өөрчлөх туршлагыг судлах төдийгүй энэ талаар нэлээд хэдэн арга хэмжээ авч бодитой алхам хийлээ. 1987 оны эхээр эдийн засгийн туршилтыг хэрэгжүүлсэн аж ахуйн газар, 1986 оныхоос 50 гаруй

хувиар нэмэгдэж, аж үйлдвэр, аж ахуйн газар, барилга, ахуйн үйлчилгээний газар, ХАА зэрэг салбарт аж ахуйн механизмыг боловсронгуй болгох ажлыг хэрэгжүүлж эхэлжээ.

1987 оны 6-р сарын 30-нд хуралдсан МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал "Үйлдвэрлэлийн үр ашиг, чанарыг дээшлүүлэх, УААА-н төлөвлөлтийн систем ба эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийг хэлэлцэж, төлөвлөлт, удирдлагын арга барилыг сайжруулах,

-Төлөвлөлтийн системийг боловсронгуй болгож, түүний шинжлэх ухааны үндэслэлийг нэмэгдүүлэх

-Аж ахуйн тооцоог нэвтрүүлж, эдийн засгийн хөшүүргийг дээшлүүлэх

-Удирдлагын бүтэц, зохион байгуулалтын ажлыг улам сайжруулах явдал мөн.

Тус бүгд хурал эдийн засгийг өөрчилж, далайцтай аж ахуйн шинэ механизмыг буй болгож, эдийн засгийн шинэчлэлийг хурдасгахад гол анхаарлаа хандуулсан юм.

1990 оноос хойш ЗХУ задарсан нь Монголын улс төрийн байдалд огцом өөрчлөлт гарлаа. 1990 оны 7-р сард МАХН-аас гадна улс төрийн зохион байгуулалттай 13 хүчин ажиллаж байлаа. Тухайлбал Монголын Ардчилсан Нам (МоАН), Монголын Социал Демократ Нам (МСДН), Монголын Үндэсний Дэвшлийн Нам (МҮДН), Монголын Ардчилсан холбоо (МоАХ), Ардчилсан Социалист Хөдөлгөөн (АСХ) гэх мэт

1991 оны 9-р сард Засгийн газрын болон зэвсэгт хүчний дээд тушаалын удирдагч, дипломат ажилтан, цагдаа болоод хэвлэл мэдээллийнхэн аливаа намын харъяалалд багтахыг хориглосон шинэ хууль тогтоов.

1992 оны 1-р сарын 13-нд Үндсэн хуулийг Улсын бага хурлаар баталж мөн оны 2-р сарын 12-ноос эхлэн албан ёсоор шинэ Үндсэн хуулийг хэрэгжүүлж, БНМАУ-ыг "Монгол Улс" хэмээн өөрчлөн нэрлэж, Монгол Улс улс төрийн ардчилсан байгууллыг дэмжиж, зах зээлийн эдийн засгийн системийг бүх талаар хэрэгжүүлж, АИХ-ыг ганц танхимтай Улсын бага хурал болгон өөрчилж, 76 гишүүнтэй байхаар тогтов.

МАХН олон хэлбэрийн эдийн засгийн байгууллыг хүлээн зөвшөөрч Монгол улсын Засгийн газар төрийн эдийн засгийн бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо дараах зохицуулалтыг хийнэ гэдгийг зарлав. Үүнд:

1. Татварын бодлогоор зохицуулан үйлдвэрлэлийн бүтцийг шинэчилнэ.

2. Мөнгөний бодлогыг зохицуулна.

3. Хувь хүнд газрыг худалдах ба түрээслэнэ.

4. Аялал, жуулчлалын эдийн засгийг хөгжүүлж, байгаль орчныг хамгаалах

5. Дэлхийн олон оронтой өргөн харилцаа тогтоон, хамтран ажиллах

1992 оны сонгуулиар МАХН, парламентын суудлын 90 гаруй хувийг авч, Жасрай тэргүүтэй шинэ Засгийн газрыг байгуулж, Монгол улсын эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөө ба хөгжлийн стратеги бодлогыг хэрэгжүүлж эхэллээ. 1994 онд УИХ-ын 56-р тогтоолоор баталсан "монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал", "Монгол улсын цэргийн номлол", "Монгол улсын аюулгүй байдлын стратеги" зэрэг эдийн засаг, нийгмийн өргөн хүрээтэй, стратеги бодлогыг хөндсөн баримт бичгүүд нь эдийн засгийн хөгжлийн стратегийг тогтоох үндэс суурийг тавьсан юм.

1995 оны 1-р сард Ерөнхий сайд П.Жасрай "Монгол улсын эдийн засгийг

ойрын үед хөгжүүлэх стратегийн зарим асуудал" гэдэг өгүүлэлдээ монгол улсын эдийн засгийн хөгжлийн 3 үе шатыг тодорхойлохдоо:

1995-2000 он бол сэргэх үе шат, 2000-2010 он хоёр дахь үе шат, дунджаар нэг хүнд ноогдох дотоодын нийт хэмжээг одоогийн хөгжиж буй орнуудын түвшинд ойртуулах ёстой. 3-р үе шат нь 2010 оноос эхлэх бөгөөд экспортын барааны үйлдвэрлэлд голлон анхаарч Ази тив, юуны өмнө Зүүн хойт Азид байр сууриа баттай эзлэх болно гэдгийг дурьджээ. Эдгээр стратегийн бодлогыг хэрэгжүүлж дуусгахын тулд эдийн засгийн хөгжлийн шинэ үе шатны загвар гаргаж, өөрөөр хэлбэл, байгалийн баялаг болон бусад баялагийг зохистой ашиглах, бүс нутагт зохицсон зам харилцааны бааз суурийг байгуулах, энэ үндсэн дээр тус улсын байгалийн нөхцөл байдал дээр тохирсон зах зээлийн харилцааны шаардлагад нийцсэн олон хэвшилт эдийн засгийн системийг байгуулах нь монгол Улсын хөгжлийн стратеги юм. Энэ гурван үе шаттай дотоодын үйлдвэрлэлийн ерөнхий зорилтоос гадна шилжилтийн үеийн хүнд хэцүү байдлыг даван туулах, ард түмний амьдралыг сайжруулах, нутаг дэвсгэрээ эзэмших, шинжлэх ухаан, техник, нийгмийн бодлого, хүрээлэн буй орчноо хамгаалах, олон улсын хамтын ажиллагаа, макро зохицуулалт, эдийн засгийн аюулгүй байдал зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хөндсөн нь дэлхийн эдийн засгийн хамтын хөгжлийн стратеги болсон юм. Монгол Улс өөрийн орны эдийн засгийг олон улсын ялангуяа, Зүүн хойт Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд, дотоодын зах зээлээ дэлхийн зах зээлийн эргэлтийн замд орууллаа.

Гэвч монгол улс одоогоор зах зээлийн багтаамж муутай. Экспортын бараа хязгаарлагдмал, мөн төлбөрийн чадвар хангалтгүй зэрэг шалтгааны улмаас олон улсын худалдаа болон урт хугацааны худалдааг ашиглахад саад болж байна. Гэхдээ хөгжингүй улсууд ба Зүүн хойт Азийн улсуудтай эдийн засаг техникийн хамтын ажиллагаагаа цаашид өргөжүүлэн хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ болоод байна.

Хятад, Монголын худалдаа 80-аад оноос хойш хоёр талын хамтын чармайлтаар, худалдааны олон арга хэлбэрээр ухаалаг зохицуулалт хийж ирсэний үр дүнд, хоёр орны худалдаа харьцангуй түргэн хөгжиж ирлээ.

Хятад, Монгол хоёр улс 1985 онд худалдааг хөгжүүлэх тухай албан нот бичиг солилцож, хэрэгжүүлж эхэлснээс хойш хил худалдааны хэмжээ түргэн өсч 1990 онд хоёр улсын хил худалдааны хэмжээ 18820000 долларт хүрэв. Одоо Хятадын гадаад худалдааны олон компани болон ӨМӨЗО, Шинжаан-Уйгарын өөртөө засах орон Монгол улстай хилийн худалдаа хийж, Хятадаас монголтой худалдаа хийж байгаа муж, хотын тоо 14 болоод байна.

1985 оноос 1989 оны 5-р сар хүртлэх хоёр орны худалдааны экспорт импортын хэмжээ 1.6 дахин өссөн бол 1989 оноос 1993 оны 5-р сар хүртэл худалдааны нийт хэмжээ 7 дахин өсч, 1993 онд Хятад, Монголын худалдааны нийт хэмжээ 200 сая америк долларт дөхөж очсон нь сүүлийн жилүүдийн хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд монгол улсын худалдаанд Хятадын эзлэх нийт хэмжээ 1989 онд 1.4 хувь байсан бол 1993 онд 31.4 хувь болж өссөн бөгөөд Хятад улсаас Монгол улсын худалдаанд эзлэх байр суурь түргэн хурдацтайгаар дээшилж, худалдааны талаар Орос улсын дараа хоёрдахь түнш болсон байна.

Хятад, Монголын худалдааны гол хэлбэр нь улсын худалдаа, бараа солилцооны худалдаа, түүхий эдийн худалдаа, гаалийн баталгаат худалдаа, хилийн ард иргэдийн зах зээлийн худалдаа зэрэг худалдааны олон хэлбэр үйлчилж байна.

Одоо Хятад Монголын худалдааны гол хэлбэр нь шилжилтийн ба зохицуулалтын шатандаа явж байна. Хятад, Монголын үйлдвэр, аж ахуйн газруудын худалдааны хэлбэр урьд нь үгүй байснаа шинээр бий болсон байна. Ялангуяа түүхий эдийг боловсруулах худалдаа харьцангуй хурдан хөгжиж байна. Түүний нэг голлох хэлбэр нь Хятадын аж ахуйн нэгжүүд Монголын түүхий эдийг боловсруулж, монголын аж ахуйн нэгжүүд сэрэдээ борлуулах хэлбэр юм.

Хятад Монголын худалдааны бас нэг онцлог нь хил орчмын ард иргэд харилцан худалдаа хийх, хувиараа хийх жижиг худалдааны хэлбэр нэн их сэргөж байгаа явдал юм. Энэ нь жирийн иргэд, ялангуяа орлого багатай давхаргын худалдан авах асуудлыг шийдвэрлэхэд гол зохицуулах үүрэг гүйцэтгэж байна.

Хятад монголын худалдааны бүтцийн онцлог нь Монгол улс анхан шатны боловсруулалт хийсэн барааг Хятад улсын аж үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүнээр арилжиж байгаа явдал юм.

Ерэнхийдээ, Хятад Монголын худалдаа нь харилцан нөхөх чадвартай, тухайлбал, Хятад улсад нэг хүнд ноогдох түүхий эд хүрэлцэхгүй байхад Монгол улс нэг хүнд ноогдох ашигт малтмал, мал, ан гөрөөс, ой мод зэрэг асар их баялагтай.

Хятадын харьцангуй өртөг хямд хөнгөн үйлдвэрийн бараа нь монголын аж үйлдвэрийн хоцрогдол, хүн амын худалдан авах чадвар доргуур байгааг нөхөх боломжтой юм.

Хятад, Монголын худалдааны хэлбэрийг улсын нэгдсэн худалдаа, бараа солилцооны гэж хувааж болно. Улсын нэгдсэн худалдааны дотор монголоос уул уурхайн бүтээгдэхүүнийг голлон экспортлож байгаа бөгөөд Хятадаас химийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг голлон экспортлож байна.

Бараа солилцооны дотор Монголоос голлон малын гаралтай түүхий эдийг экспортлож Хятадаас гол нь ургамлын гаралтай түүхий эд, хүнсний барааг сонхилон экспортлож байна.

Хятад, Монголын худалдаа сүүлийн жилд хурдан хөгжиж байгаа боловч тогтворгүй байдал байсаар байна. Худалдааны нийт хэмжээнд хэвийн хэмжээнээс давж өсөх, буурах явдал гарсаар байна. 1994 онд Хятад Монголын Худалдаа Буурч, худалдааны нийт хэмжээ 119 сая америк доллар болж 1993 оныхтой харьцуулбал 21.1 хувь буурсаны дотор экспорт буурч 47.5 хувь, импорт ялигүй өсөн 9.7 хувь байв. Экспорт импортын алдагдал 33 сая доллар болсон байна.

Мөн үеийн Хятадын худалдааны Монголын худалдаанд эзлэх хувийн жин 31.4 хувь байснаа 19.9 хувь болж буурсан байна.

1995 онд Хятад Монголын аль алиных нь эдийн засгийн бүтэц өөрчлөгдөх явцад зах зээлийн эдийн засгийн систем бүхэлдээ шинэчлэгдэн өөрчлөгдөж, хууль тогтоомж аж ахуйн нэгжүүдэд бүрэн дүүрэн зохицолдож чадахгүй байна. Аж ахуйн нэгжийн дотоод хяналт шалгалт, урамшуулалтын механизм ч тэгэлдэржиж чадаагүй байна. Хятад, Монгол хоёр улсын аж ахуйн нэгжүүд нь гадаад орчны дууриалаар сайжран өөрчлөгдөхийг дагалдан дотоод механизм ч боловсронгуй болж улмаар олон улсын худалдаанаас үлгэрлэн тэр тогтолцоонд ойртож байгаа зэрэг нь Хятад Монгол хоёр улсын худалдааны хөгжилд ихээхэн түлхэц болж байна.

Хөгжлийн цаашдын чиг хандлагыг харвал бараа солилцооны эзлэх хэмжээ аажмаар буурч, харин бэлэн мөнгөний худалдаа, хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэр аж ахуйн хоорондын худалдаа яваандаа сонхилох хандлагатай байна.

Монгол улсын зах зээлийн багтаамж бага учраас хэрэгцээт

барааны нэр төрөл олон, чанар сайн байхыг шаарддаг тул уламжлалт бараа солилцооны хэлбэр нь энэ өвөрмөц байдалд төдийлөн тохирохгүй байгаа бөгөөд яваандаа бэлэн мөнгөөр хийх худалдаагаар оруулах шаардлагатай байгаа юм. Иймээс хоёр улсын банкыг аль болох хурдан байгуулж, хамтарсан хөрөнгө оруулсан үйлдвэр, аж ахуйн дундын худалдааны давуутай талыг ашиглах нь нэгд, хоёр улсын хамтарсан үйлдвэр аж ахуйн дундын худалдаа нь лавтай давуу талтай, **хоёрт** нэр хүнд сайтай, хоёр талын барааны тоо чанарыг нийлүүлэгч тал хариуцдаг.

Хил орчмын ард иргэд харилцан зах зээл нээж ажиллах нь Хятад Монголын худалдаанд онцгой ач холбогдолтой юм. Монголын тухайд Хятадын хилд ойр суурьшдаг монгол иргэд дотоодынхоо эдийн засаг худалдааны төвөөс алслагдсан, үйлдвэрлэл явуулахад амаргүй тал бий. Хятад Монголын худалдааны хэлбэр нь аажмаар олон шинж хэлбэртэй болж байгаа бөгөөд үйлдвэр аж ахуйн газруудын хоорондын худалдаа, хөрөнгө оруулалт хийсэн худалдаа, хил орчмын байнгын ажиллагаатай зах. зээлийн худалдаа гэсэн гол хэлбэр байна.

Улирлын болон тээврийн нөхцөлөөс шалтгаалан Хятад Монгол хоорондын ургамал амьтны гаралтай түүхий эдээр хийх худалдаа ихээхэн хязгаарлагдмал байдалд байна. Хэрвээ Хятад улс амьтны гаралтай бүтээгдэхүүн боловсруулах технологи, ургамал тарьж ургуулах арга ажиллагаа, ялангуяа хүлэмжинд хүнсний ногоо тарих аргыг Монгол дэлгэрүүлж чадвал Хятад Монгол хоёр орны аль алинд нь эдийн засгийн хувьд бодитой үр ашиг өгөх юм. Үүнээс гадна Монгол улсын зах зээл дээр тахианы мах, өндөг, гахайн мах ихээхэн дутмаг байгаа бөгөөд үнэ нь хэт өндрийн дээр энэ нь голдуу импортоор ордог боловч эдгээр амьтныг тэжээх түүхий эдийг их хэмжээгээр экспортлож болох юм.

Хятад Монголын худалдаанд хэлбэршин тогтож буй нөөц баялагаа харилцан нөхөх онцлог ба үйлдвэрлэл эрхлэхэд хөдөлмөрийн хуваарь, ижил тал байгаа бөгөөд Монгол улсад үйлдвэрлэлийг сэргээх арга замыг эрж сүвэгчлэх явцдаа анхдагч түүхий эдийг экспортлохоо багасгаж бэлэн, хагас бэлэн бүтээгдэхүүн экспортлох хэмжээгээ нэмэгдүүлэх явдал зайлшгүй шаардагдаж байна.

Ийм учраас Хятад, Монголын худалдааны одоогийн байдлыг харвал Хятад улс Монголын анхдагч түүхий эдийг бэлэн бүтээгдэхүүнээр сольж авч байгаа онцлог нь Монголын үндэсний аж үйлдвэрээ сэргээн хөгжүүлэх үндсэн бодлоготой зөрчилдөж байна. Зөвхөн арьс ширээр жишээлж үзвэл 1994 онд Хятад улс Монголоос экспортлосон арьс ширний 80 хувийг импортоор авсан байхад Монгол улсын арьс ширний үйлдвэрүүд түүхий эд хүрэлцэхгүйгээс болоод зогссон буюу хагас зогссон байна. Ийм зөрчилт байдлыг Хятад улс үйлдвэрлэл, хөдөлмөрийн хуваарь, худалдааны ямар бодлого барьж зохицуулах вэ гэдэг нь Хятад Монголын худалдааны төлөвт гүнзгий нөлөөтэй юм.

Хятад Монголын худалдаа нь байгалийн асар их давуу талтай. Энэ давуу талаа түшиглэн хоёр тал худалдаа үйлдвэрлэл, хөдөлмөрийн хуваариа зохицуулан хөгжүүлж чадах юм. Ийм зохицуулалт хийхгүй бол харилцан үл ойлголцох, болгоомжлох, сэтгэл зүйн шахалт хавчилт үзүүлэх байдал аль аль талдаа гарч болох юм.

Иймээс худалдаа, үйлдвэрлэл, хөдөлмөрийн хуваарь дахь зөрчлийн үндсийг олж шийдвэрлэх нь монгол улсын үйлдвэрлэлийн бүтэц сэргэн хөгжихөд ихээхэн дэмжлэг туслалцаа болох бөгөөд ялангуяа мал аж ахуйн гаралтай түүхий эдээ түшиглэн Монгол Хятадын хамтарсан хөрөнгө

оруулалттай хонины ноос угаах үйлдвэр байгуулах, угаасан ноосоо экспортлож жил бүр аажмаар нэмэгдүүлэхийн зэрэгцээ Хятадын тал дотоодын зах зээл дээрээ харьцангуй өндөр үнээр борлуулах нь, хөрөнгө оруулсан хоёр талд аль алинд нь ашигтай.

Хятад улс бол Монгол улсын хоёр том хөршийн нэг болохын хувьд монголын худалдаа, аж үйлдвэр, хөдөлмөрийн хуваарь мэдэгдэхүйц давуу байдал, хөгжлийн нээц бололцоотой юм. Ийм учраас Хятад улс одоогийн Монголд хөрөнгө оруулж буй бодлогодоо аажмаар зохицуулалт хийж шаардлагатай бөгөөд ийм зохицуулалт нь ойрын хугацаанд нь ч элс хэтдээ ч ашигтай. Алс хэтийн ашиг нь Монголын зарим том үйлдвэрт хөрөнгө оруулж, аажмаар Хятадын эдийн засгийн цар хүрээ ба хүчин чадалтай зохицуулах, энэ бүхэн нь Хятад Монгол тус тусынх нь дотоод болон олон улсын зах зээлд өсөн өндийж, хөгжиж, бололвсронгуй болгоход ашигтустай болно. Эдүгээ дэлхий дахинаараа Хятадыг улс төр, эдийн засаг цэргийн талаар том гүрний байр суурьтайг хүлээн эзэмсрөхөөс өөр аргагүй болж байгаа учраас Хятад улс эргэн тойрны орнуудтайгаа харилцахдаа улс төр, эдийн засгийн харилцааг аажмаар гүнзгийрүүлж, хөгжүүлэх, бүс нутгийн эерчил, тогтворгүй байдлыг багасгаж, баталгаажуулах алхам хийх нь чухал болж байна.

Монгол улсын сүүлийн жилүүдийн гадаад худалдаа, гадаад харилцааны хөгжлийн агуулгаас харвал Монгол улсын уламжлалт худалдааны түншүүдтэй хийж байгаа худалдааны хэмжээ жилээс жилд буурч европ, америк болон ялангуяа Азийн улс орнууд, бүс нутагтай хийж байгаа худалдааны хэмжээ жил дараалан хурдацтай өсч байгааг тодорхой харж болно. Монгол улсын гадаад худалдааны 80 орчим хувь нь Зүүн хойт Азийн бүс нутагт ноогдож байгаа бөгөөд Зүүн хойт Азийн орнууд монголд оруулж байгаа шууд хөрөнгө оруулалтын хагасаас илүү хувийг оруулж байна.

Монгол улсын эдийн засгийн сэргэлт хөгжилд Азийн бүс нутгуудтай тогтоосон хоёр талын болон олон талын төрөл бүрийн харилцаа, түүний дотор улс төр, эдийн засгийн харилцаа онцгой үүрэгтэй бөгөөд түүнийг зүй зохистой эс ашиглаж чадваас мухардалд орж болошгүй юм.

Эдгээр тодорхой хандлагыг үндэслэн үзвэл Хятад Монголын харилцааны агуулгыг гүнзгийрүүлэн, улам бодит чиглэлтэй болгож, судалгааны төслийг эртхэн боловсруулах, тогтвортой, урт хугацааны ашигт тулгуурласан хөгжлийн хамтын орчин шаардлагатай байна. Үүний зэрэгцээ цаг үедээ тохирсон хөгжлийн зүй зохистой бодлого боловсруулах нь улс тус бүрийн дотоод гадаад хоёр зах зээлийг нээх, үр ашиг бүхий түшиц газрыг бий болгох, хамтын хөгжил цэцэглэлтэнд түшиц тулгуур болоход хувь нэмрээ оруулах юм.